2020 оны 10 сарын 16-ны өдөр Дугаар А/1197 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 92 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 28/27 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 5.4.6-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зүүн хойд Азийн хотуудын өмнө тулгарч буй асуудлуудыг хэлэлцэх, харилцан туршлага солилцох, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Зүүн хойд Азийн Хотын дарга нарын 4 дэх удаагийн ээлжит форумыг 2020 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотод цахимаар зохион байгуулсугай.

2.Тус форумыг “Цар тахал, байгалийн гамшгийн үед эрсдэлийн менежментийг сайжруулж, хотуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь” сэдвийн хүрээнд зохион байгуулах тул нийслэлийн хэмжээнд хариуцан ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ахлагч -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Уртнасан

Гишүүд:
-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ү.Ганболд;
-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Д.Чинзориг;
-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Хулан;
-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батбаатар;
-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Мягмаржав;
-Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын дарга О.Чинзориг;
-Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга Л.Баярсайхан;
-Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Л.Төмөрбаатар;

-Зүүн хойд Ази судлалын эксперт, зөвлөх С.Бадрал /зөвшилцсөнөөр/;
-Азийн сангийн мэргэжилтэн Б.Халиун /зөвшилцсөнөөр/.

Нарийн бичгийн дарга -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Отгонсүрэн.

3.“Зүүн хойд Азийн Хотын дарга нарын 4 дэх удаагийн форум” арга хэмжээг өндөр хэмжээнд зохион байгуулан, үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг /Ц.Уртнасан/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН НЭГДҮГЭЭР
ОРЛОГЧ Ж.БАТБАЯСГАЛАН